



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/71

Рашаант сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 03 -ны өдрийн А/65 дугаар захирамжийн дагуу 2024 оны 07 дугаар сарын 05, 08-ны өдөр тус тус явагдах газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Идэр (Сумын засаг даргын орлогч)

Гишүүд: М.Билэгдэмбэрэл (Сумын Байгаль орчин хяналтын улсын байгцаагч)

Нарийн бичгийн дарга: Б.Батмөрөн (Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу хариуцлагатай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Идэр) -т даалгасугай.

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлагатай ажиллахыг анхааруулсугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

D:\nasaa bichig hereg\A-Zax.doc

6706011133